

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, аймгийн Засаг даргаас 14 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг тооцон ажилласан.

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлыг 1 удаа зохион байгуулж, 2 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Тулгар төрийн 2232 жил, Их Монгол Улсын 817 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 112 жил, Ардын хувьсгалын 102-н жилийн ой, Үндэсний их баяр наадам, Говьсүмбэр аймгийн баяр наадмыг 2023 оны 07 дугаар сарын 6, 7-ны өдрүүдэд, Шивээговь, Баянтал сумын үндэсний баяр наадмыг 07 дугаар сарын 10-ны өдрүүдэд тус тус тэмдэглэн өнгөрүүлээ. Говьсүмбэр аймгийн баяр наадмыг тохиолдуулан “Боржигин соёлын отог” соёлын наадмын үйл ажиллагааг зохион байгуулсан. Соёлын наадмын хүрээнд зохион байгуулагдсан “Дээлтэй монгол” тэмцээнд 17 гэр бүлийн төлөөлөл оролцож, “Дэмбээ тэмцээн” 21 иргэн оролцож, тус тус 3 байр шалгаруулсан. Мөн Боржигин чуулга сумдын өвлөн уламжлагчдын урлагийн тоглолтууд зохион байгуулагдлаа.

Цагдаагийн байгууллагын аймгийн Баяр наадмын үеийн хамгаалалт, зохицуулалтад 2 өдрийн турш давхардсан тоогоор 111 алба хаагч үүрэг гүйцэтгэж ажилласан.

Баяр наадмын өдрүүдэд морины бүртгэл хийхийн зэрэгцээ уралдах морьдын сэрвээний өндрийг олон улсын стандартад нийцсэн лазар хэмжигчээр хэмжих, шүдлэх ажлыг хийж ажиллалаа.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 04-ний А/221, Өмнөд бүсийн төв-Өмнөговь аймгийн Онцгой байдлын газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 06-ны А/03, Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/49 дугаар тушаалаар Монгол Улсын тулгар төрийн 2232, Их Монгол Улс байгуулагдсаны 817, Ардын хувьсгалын 102 жилийн ой, Үндэсний их баяр наадмын тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан Онцгой байдлын газрын алба хаагч нарыг 2023 оны 07 дугаар сарын 10-ны өдрөөс 07 дугаар сарын 16-ны өдрийг дуустал өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэн, өдөр бүр Ёс журмын эргүүлийн хуваарийг гарган хэрэгжилтэд хяналт тавьж, Онцгой байдлын ерөнхий газрын ерөнхий эргүүл, шуурхай удирдлагын ерөнхий зохицуулагчтай холбоонд орж ажилласан.

Онцгой байдлын газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/49 дугаар тушаалын хэрэгжилтийг хангуулан 2023 оны 07 дугаар сарын 09-ний өдөр “Цуглар улбар шар” дохиогоор ажиллуулан албаны шуурхай болон аврах, гал унтраах автомашин, техник, тоног төхөөрөмж, эрэн хайх, аврах ажиллагааны багаж, холбоо, зарлан мэдээллийн хэрэгслийн бэлэн байдлыг 1 удаа зохион байгуулж, шаардлагатай тохиолдолд гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх алба хаагч нарыг томилгоожуулан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийн зааварчилгаа өгч ажиллалаа. Мөн тусгай зориулалтын болон шуурхай албаны автомашин, гал унтраах багаж хэрэгсэл, Эрэн хайх, аврах ажиллагааны тоног төхөөрөмж ялангуяа уснаас эрэн хайх, аврах ажиллагааны моторт завь, /хийлдэг дэр, хантааз, олс, бусад зүйлс/ хүн нэг бүрийн хээрийн үүргэвчийг шалгаж, болзошгүй гамшиг осол, эрэн хайх аврах ажиллагааны бүлгийг холбооны техник хэрэгслээр хангах, холбоо зохион байгуулалтыг хийх зорилгоор 4 төрлийн 8 техник хэрэгслийг Шуурхай удирдлагын зарлан мэдээллийн төв дээр байрлуулан хадгалалт, цэнэглэлтийг тухай бүр хийн бэлтгэл бэлэн байдлыг ханган ажилласан. Дээрх тоног төхөөрөмжид 1 иридиум утас, 2 үүргэвчин станц, 3 байршил тогтоогч, 8 гар станц зэрэг төхөөрөмжийг байнгын бэлэн байдалд байлган томилгоот бүлгийг холбооны техник хэрэгслээр ханган гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх албаны бэлтгэл бэлэн байдлыг

ханган ажилласан. Сумдын ерөнхий зориулалттай мэргэжлийн анги, Гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, Баяр наадмын өдрүүдэд үүрэг гүйцэтгэх хүн хүч, техникийн хэрэгслийн судалгааг гарган Онцгой байдлын ерөнхий газрын Ажиллагааны удирдлагын газарт хүргүүлсэн.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, орлого бүрдүүлэлтийг эрчимжүүлэн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж.

2023 оны 07 дугаар сарын нийт татварын орлогын төлөвлөгөө 6440,9 мянган төгрөг гүйцэтгэлээр 7230,7 мянган төгрөг буюу 112%, үүнээс Улсын төсвийн орлогын төлөвлөгөө 988,7 мянган төгрөг гүйцэтгэлээр 1185,0 мянган төгрөг буюу 120% гүйцэтгэлтэй байна. Сумдын төсвийн орлогын төлөвлөгөө 3837,9 мянган төгрөг төвлөрүүлэхээс 4431,4 мянган төгрөг буюу 115,4%, аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 1614,2 мянган төгрөг төвлөрүүлэхээс 1614,2 мянган төгрөг буюу 100%-ийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна.

Татвар төлөгчдийн бүртгэлийг сайжруулж, татварын бааз суурийг нэмэгдүүлэх хүрээнд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 700 хуулийн этгээд бүртгэлтэй байсан бол 2023 оны 07 дугаар сарын 24-ны байдлаар 707 болж өссөн Үүнд: Татвар төлөгчдийн хариуцлагын хэлбэрээр харуулбал: Үүнд: ХК-1, ХХК-370, ББН -5, ЗБН -11, Хоршоо -31, ХЗХоршоо- 1, ОНӨҮГ-6, Салбар-66, төсөвт болон төрийн бус байгууллага, сан ОНБ – 216 байна.

Шивээговь сумын Засаг даргын Тамгын газарт татварын пос машинаар иргэдэд үйлчилж, татварыг цахимаар бүрдүүлж байна. Орон нутгийн 15 нэр төрлийн татварын орлого бүрдүүлэхээс 14 хоногийн байдлаар Цалин түүнтэй адилтгах орлогын албан татвар, Газрын төлбөр, Хог хаягдлын үйлчилгээний төлбөр, Түгээмэл тархацтай АМНАТ, Хөрөнгө борлуулсны орлого гэх мэт татварын дансуудад орлого бүрдээд байна. Орон Нутгийн татварын орлого гүйцэтгэлээр 133,072,780 төгрөг бүрдсэн байна.

Сүмбэр сумын ЗДТГ-ын 2023 оны 6 сарын 30-ны байдлаар орон нутгийн орлогын төлөвлөгөө 2195,4 сая төгрөг, гүйцэтгэл 2917,5 сая төгрөг буюу 132,8 хувьтай, орон нутгийн авлага 6860,0 мянган төгрөг, өглөг 39738,5 мянган төгрөг байна.

Статистикийн чирглэлээр

Мал төллөлт, төл бойжилтын ХАА-1, Том малын зүй бус хорогдлын ХАА-2 мэдээг 10 багаас, Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн ХАА-3, Жимс жимсгэнэ тариалсан талбайн ургац хураалтын ХАА-5, Газар тариалангийн бүтээгдэхүүний ХАА-10 мэдээг хуваарийн дагуу хугацаанд нь бүрэн авч сар бүр ҮСХ-д дамжуулсан.

Аж үйлдвэрийн салбарын АҮ-1, үнийн АҮСҮ-1, Мал эмнэлгийн үйл ажиллагааны МЭ-1, Худалдааны салбарын үнийн ХСҮ-1, Зочид буудлын үйл ажиллагааны ЗБ-1, Зоогийн газрын үйл ажиллыгааны ЗГ-1, Аялал жуулчлалын үйл ажиллагааны АЖ-1а, Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын ХО-ЗБ мэдээнүүдийг ААНБ-аас хугацаанд нь бүрэн авч ҮСХ-д дамжуулсан.

Аймгийн 2023 оны 06 Нийгэм эдийн засгийн танилцуулга болон хэвлэлийн бага хурлыг бэлтгэн нийтэлсэн.

Хэрэглээний бараа үйлчилгээний үнийн сарын Үнэ-21 мэдээг 1 удаа, 7 хоногийн үнийн Үнэ -2 мэдээг 4 удаа дамжуулсан.

АХС, НОАБС-ы 30 өрхөөр судалгаанд явсан. Судалгааны тодруулгуудыг тухай бүр тодруулан ҮСХ-д дамжуулсан.

Санхүүгийн хяналт, аудитын чиглэлээр

Боржигин өв музейн 2022-2023 оны 5 сар хүртэлх үйл ажиллагаанд дотоод аудит хийж дунд эрсдэлтэй буюу сайжруулах шаардлагатай гэсэн дүгнэлтийг өгч байна. Аудитаар илэрсэн 7 асуудлын 5 асуудал буюу 71 хувь нь нөлөө ихтэй гэж үзсэн. Шалгалтаар 10 зөвлөмж өгсөн.

Сүмбэр сумын ЗДТГазрын 2022-2023 оны эхний 5 сарын үйл ажиллагаанд дотоод аудит хийлээ. Дотоод аудитаар тус байгууллага дунд эрсдэлтэй буюу сайжруулах шаардлагатай гэсэн дүгнэлтийг өгсөн. Шалгалтаар илэрсэн зөрчлийн хүрээнд 3 зөвлөмж өгсөн.

Байгаль орчин аялал жуулчлалын газрын 2023 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу 2022-2023 оны 6 сар хүртэлх санхүүгийн болон үйл ажиллагааны баримтад санхүүгийн болон дотоод аудит хийж эрсдэлгүй буюу хангалттай гэсэн дүгнэлтийг өгсөн.

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нийт 43 байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллаж, эхний 6 сарын шилэн дансны мэдээ оруулалтын байдал 94,8 хувьтай байна. Энэ нь өмнөх сараас 3,3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын хүрээнд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цахим хуудас болон фейсбүүк хуудас, Хууль Эрх зүйн хэлтсийн фейсбүүк хуудсаар дамжуулан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Хог хаягдлын тухай” хуулиар постер бэлтгэж, “Авлигын эсрэг нэгдье” аяны 10 мэдээллийг нийт 428 иргэнд түгээж ажилласан.

Архивын тасаг: Архивийн баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 2 хөмрөгийн 12 хадгаламжийн нэгжийн 1360 хуудас, 664 заалт, 3137 хүний нэр, 971 байгууллагын нэр, 1582 газар зүйн нэр, 985 потошоф, 1232 скайнер, 974 холболт хийж ажилласан. 2023 оны 07 дугаар сард 27 иргэнд лавлагаа гаргаж үйлчилгээ үзүүлсэн.

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС

Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр гадаад паспорт захиалсан- 132
- Иргэний үнэмлэх шинээр олгосон- 41
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо— 17
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо - 1
- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо -1
- Нас барсныг бүртгүүлсэн тоо - 9
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн - 19
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо - 24
- Тоон гарын үсэг олголт - 101

Нийт 345 иргэнд төрийн үйлчилгээг үзүүллээ.

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 12
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 7
- Гэрээний бүртгэл - 44
- Барьцааны гэрээний бүртгэл - 136
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга - 5

Нийт - 204

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл -
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт -4
- Татан буугдсан хуулийн этгээдийн бүртгэл -

Нийт - 4

Архивын чиглэлээр:

- Төрийн байгууллагад гаргасан лавлагаа, хуулбар - 33
- Хуулийн этгээдэд гаргасан лавлагаа, хуулбар - 4
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар - 86

Нийт- 119

Нийт 672 иргэнд төрийн үйлчилгээг үзүүлж ажиллалаа.

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД

Тус алба нь хэргийн газрын үзлэгт- 15 үүнээс хүний амь нас хохирсон-3, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан-2, хулгайлах гэмт хэрэг-1, дээрэмдэх-0, зам тээврийн осол-2, эд хөрөнгө устгах гэмтээх-1, бусад-6. Хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 325 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан. Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэг-13, үүнээс хүнд-0, хүндэвтэр-1, хөнгөн-2, гэмтлийн зэрэгт хамаарахгүй-5, гэмтэл тогтоогдоогүй-5, цогцост хийсэн шинжилгээний тоо-2 байна.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАР

Нэг. Сургалт, хүмүүжлийн ажлын чиглэлээр

Тайлант хугацаанд нийт 10 хоригдолтой “Нийгмийн ажлын үйлчилгээний гэрээ” байгуулж, “Хорих ял эдлэх үеийн жишиг хөтөлбөр”-ийн дагуу нийгэмшүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан ажилласан.

2023 оны 07 дугаар сарын байдлаар 105 хоригдол ар гэрийн хүсэлтийн дагуу цахим уулзалтад хамрагдсан. Цахим уулзалтыг зохих журмын дагуу бичиг хэргийн ажилтан хорих ангийн sainuu425@gmail.com хаягт хоригдлын ар гэрээс хүсэлтийг хүлээн авч хүний тоо бүртгэлийн байцаагчид өгч эргэлтийн бичгийг үндэслэн зохион байгуулан ажиллаж байна. Хоригдлуудын ар гэрээс гомдол санал гараагүй. Цахим уулзалтаар ял эдлэгсдийн сэтгэл зүйн байдлыг тогтвортой байлгах, буруу зүйлд автаж болзошгүй байдлаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд яриа таниулга хийж, цахимаар уулзалт явуулан хоригдлуудын зүгээс үйлдэж болзошгүй гэмт хэрэг зөрчил, сэтгэл зүйн өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэн ажиллаж байна.

Хоригдлуудад тулгамдаад буй асуудлуудад тухай бүр эрх зүйн зөвлөгөө өгч, яриа таниулга хийн нийт 46 хоригдлын гаргасан хүсэлтийг хүлээн авч ангийн удирдлагад танилцуулан холбогдох албан тушаалтан, байгууллагад зохих журмын дагуу явуулж зөрчилгүй шийдвэрлэж ажилласан.

Тайлант хугацаанд суллахад бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд Говьсүмбэр аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран ажиллах төлөвлөгөөний хүрээнд 2 цагийн сургалт зохион байгуулсан. Суллагдах дөхсөн хоригдлуудыг холбогдох сургалтад хамруулж, суллагдсаны дараа 8 хоригдлыг “малчин”, “хувийн компанид туслах ажилтан” гэх зэрэг ажлын байранд зуучилсан.

Хоригдлуудад нийгэм цаг үеийн байдал, нээлттэй ажлын байрны тухай мөн нийгмийн халамж үйлчилгээний байгууллагууд болон суллагдан гараад очих орон нутгийн замын маршрут, тээврийн зардлын талаарх сургалтыг үр дүнтэй зохион байгуулсан.

Тайлант хугацаанд гэм хорын төлбөртэй 69 хоригдол ял эдэлж байна. Хохирол төлбөртэй хоригдлуудаас хохирол төлөх боломжтой 37 хоригдолтой ганцаарчлан уулзалт зохион байгуулж, хохирол төлөх боломжгүй 27 хоригдлын цалинтай ажлын байраар хангах талаар судлан ажиллаж байна.

Хорих ангид сувилагч нар амбулаторын үзлэгээр давхардсан тоогоор 374 хоригдол, давтан үзлэгт 126 хоригдол, эмчийн хяналтад байгаа 4 хоригдолд давхардсан тоогоор 150 удаагийн үзлэг хийж эмчийн жороор эм олгож, зөвлөгөө өгч ажиллалаа.

2023 оны 07 дугаар сарын байдлаар нийт 226 хоригдлыг регистрийн дугаараар эрүүл мэндийн даатгал төлсөн эсэх талаар мэдээллийг шүүж дутуу төлөлттэй 226 хоригдлын судалгааг гаргаж эрүүл мэндийн даатгалыг бүрэн төлүүлсэн. Одоогоор эрүүл мэндийн даатгал дутуу төлөлттэй хоригдлуудын ар гэр болон төрийн бус байгууллагатай хамтран үр дүнтэй ажил зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Хоригдлын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, авъяас чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор гитар хөгжмийн дугуйланд 10 хоригдол, шагайн харваан дугуйланд 34 хоригдол, шатар, даамны дугуйланд 40 хоригдол, морин хуурын дугуйланд 6 хоригдол хамрагдаж байгаа бөгөөд сургалтын бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, сэтгэн бодох чадварыг сайжруулах, хувь хүний хөгжлийг дээшлүүлэх зорилгоор сургалтын бүсэд зургын дугуйланд 7 хоригдол хамруулсан.

Хоёр. Шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр

2023 оны 07 дугаар сарын байдлаар 261 гүйцэтгэх баримт бичгийн 25360017,1 төгрөг, 101 гүйцэтгэх баримт бичгийн 6155723,2 төгрөгийг бодитой биелүүлж 160 гүйцэтгэх баримт бичгийн 19204293,9 төгрөгийн үлдэгдэлтэй байна. 2023 оны 07 дугаар сарын гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 40,1 % хувьтай ажиллаж байна.

ЦАГДААГИЙН ХЭЛТЭС

Цагдаагийн хэлтэс нь Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 202/ “Гэмт хэрэг зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах” журамд заасны дагуу 2023 оны 07 дугаар /06.21-07.20/ сард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 73 гомдол, мэдээллийг хүлээн авч шалгаснаас гэмт хэргийн 20, зөрчлийн 53 гомдол мэдээлэл байна. Тайлангийн хугацаанд зөрчил үйлдсэн 1657 иргэнийг эрх бүхий албан тушаалтнаас болон шүүхээс 41,350,000 төгрөгөөр торгож, согтуугаар зөрчил гаргасан 1 хүнийг эрүүлжүүлж, 15 хүнийг шүүхээр баривчлуулан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 16 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан байна.

Хариуцсан нутаг дэвсгэрийн эрүү, хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор давхардсан тоогоор худалдаа, үйлчилгээний үйл ажиллагаа эрхэлдэг 142 цэгийн үйлчилгээний цагийн хуваарьт өдөр тутам хяналт шалгалт хийж, зөвлөгөө өгч ажилласан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр гудамж талбай, олон нийтийн газарт гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр сүмбэр сумын нутаг дэвсгэрт найрамдал хотхон, дэнж, төмөр зам, аяганы хонхор чиглэлд өдөр 14:00-20:00, орой 20:00-04:00 цагуудад, Баянтал сум, Шивээговь сумдын нутаг дэвсгэрт 10:00-16:00 цаг, 18:00-00:00 цагийн хооронд эргүүлийг тасралтгүй зохион байгуулж давхардсан тоогоор 360 алба хаагч 2460 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгууллага, аж ахуйн нэгжийн халдвар хамгааллын дэглэмийг сахиулж, заавар зөвлөгөө өгч ажиллалаа. Гудамж талбай, олон нийтийн газар болон авто замд зөрчил гаргасан 194 хүнийг 9,120,000 төгрөгөөр торгож ажиллалаа.

Энэ оны 07 сард гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг цахим хэлбэрээр олон нийтэд хүргэх, хууль сурталчилах, ухуулах, цаг үеийн болон нөхцөл байдлын талаарх мэдээ мэдээллийг түгээх ажлыг тасралтгүй зохион байгуулж, төв, орон нутгийн холбогдох

байгууллагаас цахим орчинд нийтэлсэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх санамж, анхааруулга, зөвлөмж 25 видео шторк 15, бусад 10 нийт 50 мэдээллийг "Говьсүмбэр аймгийн цагдаагийн хэлтэс" пэйж хуудсанд байршуулж, иргэд, олон нийтэд түгээж, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сурталчилав.

Аймгийн Онцгой байдлын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран болзошгүй осол, гэмтлээс сэргийлж, хаялга нуур орчимд эргүүл хяналтыг хуваарийн дагуу хийж ажилласан.

Тээврийн цагдаагийн албанаас зохион байгуулсан "Нэг зам нэг соёл" аяны хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газар, жолооны курсүүд, даатгалын байгууллагуудын төлөөлөлтэй хамтран жолооч нарын дунд хөгжөөнт тоглоом тоглуулах, сугалаа сугалуулах, гарын бэлгээр урамшуулах, эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажилласан.

Бага насны хүүхдийг хараа хяналтгүй орхихгүй байх, үер усны аюулаас сэргийлэх ажлын хүрээнд видео зөвлөмж 1 бэлтгэн байгууллагын фейж хуудсандаа түгээж, зөвлөмж 1400 ширхэгийг тарааж ажилласан.

ДӨРӨВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр:

Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбоотой аймгийн хэмжээнд 3 наадам зохион байгуулагдаж, нийт 150 уралдаанч хүүхдийн бүртгэл мэдээллийг хөтлөх, аюулгүй байдлыг хангах, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох наадмын комисстой хамтран ажилласан байна.

Аймгийн баяр наадам 2023 оны 07 дугаар сарын 06, 07-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, 6 насны морьдын уралдаанд нийт 87 уралдаанч хүүхдийг бүртгэн, стандарт шаардлагад нийцсэн хувцас хэрэглэлтэй, 8 ба түүнээс дээш насны уралдаанч хүүхэд хурдан морь унахад хяналт тавьж ажилласан.

Соёл, урлагийн чиглэлээр: "Соёлын сэргэлт-2023" арга хэмжээний хүрээнд: Соёл урлаг судлалын хүрээлэнгээс "Монгол хүний эрхэмлэн дээдлэх үнэт зүйл ба ёс суртахууны асуудал" сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн. Мөн зураач Ч.Хосбаярын Түмний хайртай дүрүүд миний сэтгэлийн өнгөөр гэрэл зургийн үзэсгэлэн гаргаж толилууллаа. Боржигин чуулгын уран бүтээлчид БНХАУ-д оролцсон. Сумдад "Соёлын сэргэлт" арга хэмжээ зохион байгуулсан.

Биеийн тамир, спортын чиглэлээр: Баянхонгор аймгийн Баянхонгор суманд 2023 оны 06 дугаар сарын 19-29 хүртэл хугацаанд зохион байгуулагдсан Монголын хүүхдийн спортын зуны VII наадмын шигшээ тэмцээнд манай аймгаас спортын 15 төрөлд 145 тамирчин, 14 дасгалжуулагч оролцож, 3 алт, 7 мөнгө, 4 хүрэл медаль хүртсэн амжилт үзүүлсэн.

Монголын хүүхдийн спортын зуны VII наадмын боксын төрлөөр манай аймгийн өсвөрийн баг тамирчид амжилттай оролцон, 1 алт, 3 мөнгө, 1 хүрэл нийт 5 медаль хүртлээ.

Аймгийн хэмжээнд албан байгууллага, аж ахуйн нэгжийн биеийн тамир, спортын арга зүйч, албан хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх биеийн тамирын арга хэмжээг оновчтой үр дүнтэй зохион байгуулах зорилгоор ажлын байран дээр нь очиж "Хүн амын бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил" авсан. Сорил авах ажиллагаанд 4 байгууллагын нийт 869 иргэн хамрагдаж, сорилын хариуг цахим программд шивж, сорилд хамрагдсан иргэдийн 56,0 хувь нь А,В,С үнэлгээтэй байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Говьсүмбэр аймгийн хараагүйчүүдийн холбоо, Биеийн тамир, спортын газар хамтран Говьсүмбэр аймагт анх удаа харааны бэрхшээлтэй иргэдийн дунд "Хонхот бөмбөгийн тэмцээн"-ийг 2023 оны 06 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус тэмцээнд Дорноговь, Сүхбаатар, Хэнтий, Говьсүмбэр гэсэн 4 аймгийн

50 гаруй тамирчин мэдрэмж, хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөнөөс эрэгтэй төрөлд Хэнтий аймгийн, эмэгтэй төрөлд Дорноговь аймгийн баг тамирчид тэргүүлээ.

Эрүүл мэндийн талаар: Эрүүл мэндийн үзүүлэлт

Үзүүлэлт	2022 оны 7 сар	2023 оны 7 сарын 20-ны байдлаар
Төрсөн эх	199	200
Гэрийн төрөлт	1	1
Амьд төрсөн хүүхэд	197	201
Амьгүй төрөлт	2	0
Нас баралт	52	47
Эмнэлгийн нас баралт	14	15
Хоног болоогүй нас баралт	5	4
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	2
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	1	0
Эмнэлгээс гарсан хүний тоо	3910	3337
Амбулаторийн үзлэг	68636	70985
Халдварт өвчин	2357	227

Монголын сумын эмч, мэргэжилтнүүдийн холбооны дэмжлэгтэй 2020-2023 онд сүрьеэ өвчнөөр өвчлөгсдийн хавьтлыг эрт илрүүлэх үзлэг, шинжилгээнд хамруулах тухай аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2023 оны А/21 дүгээр тушаалын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэхүү үзлэг, шинжилгээнд нийт 32 өвчтөний 159 хавьтлыг хамруулан, сүрьеэ өвчний 3 шинэ тохиолдлыг эрт илрүүлэн эмчилгээ, хяналтанд авч, халдварын тархалтыг бууруулахад үр дүнтэй үйл ажиллагааг зохион байгуулсан. Мөн аймгийн Нэгдсэн эмнэлгийн сүрьеэгийн диспансерийн эмч, мэргэжилтэн сумдын эрүүл мэндийн төвийн сүрьеэ өвчинтэй тэмцэх, сэргийлэх чиглэлээр хийж буй үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийж, мэргэжил арга зүйгээр ханган ажилласан.

Аймгийн наадам болохтой холбогдуулан хоол, хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхээр бүртгүүлсэн 25 аж ахуйн нэгж, иргэний 34 ажилтанд хоол хүнсээр дамжих халдвар, хордлогоос сэргийлэх зөвлөгөө мэдээллээр хангах, дэмжлэг үзүүлэх сургалтыг 2023 оны 07-р сарын 03-ны өдөр зохион байгуулсан. Тус сургалтаар “Эрүүл ахуйн зохистой дадлыг мөрдөх, бүтээгдэхүүний хадгалалт, хугацаа, чанар, аюулгүй байдал” сэдвээр зөвлөмж боловсруулан сургалтын гарын авлагаар ханган ажилласан.

Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:

Ажил олгогчоос ирүүлсэн сул чөлөөтэй ажлын байрны захиалга болон ажил зуучлагдсан иргэдийн мэдээллийг хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн санд ажил хайгчаар 10 иргэнийг бүртгэж оруулсан ажил зуучлалд 5 иргэнийг байнгын ажлын байранд зуучилсан, түр ажлын байранд 21 иргэнийг зуучилсан.

Төрийн болон хувийн хэвшлийн 100 байгууллагыг И-ЖОБ платформ хөдөлмөрийн зах зээлийн нэгдсэн системд бүртгэсэн.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээ:

2020-2022 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт хамрагдсан иргэдийн төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, эргэн төлөлтийг хуваарийн дагуу 79.6 хувьтай төвлөрүүлсэн байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээ: 2023 оны 07 дугаар сарын 19-ний байдлаар зорилтот бүлгийн иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг нийт 12070 иргэнд цаг тухайд нь олгож, түргэн шуурхай үйлчилсэн.

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 1 удаа зохион байгуулж, 6 иргэний асуудлыг хэлэлцсэн.

№	Үзүүлэлт	2023.01.01 2023.07.19
		Хүн тоо
1	Халамжийн тэтгэвэр	258
2	Нөхцөлт мөнгөн тэтгэмж	254
3	Амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж	242
4	Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	710
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	91
6	Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмж	142
7	Алдарт цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	
8	Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж	1427
9	Цалинтай ээж	701
10	Хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа	280
11	Насны хишиг	742
12	Өрх толойлсон эх, эцгийн тэтгэмж	42
13	Ихэр хүүхдийн тэтгэмж	1
14	Олон нийтийн оролцоонд түшиглэлэсэн халамжийн үйлчилгээ	4
15	Хүүхдийн мөнгөн тэтгэмж	7176
Нийгмийн халамжийн сангийн дүн		12070

2023 оны 07 дугаар сарын хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд аймгийн хэмжээнд 49 өрхийн 280 гишүүнийг хамруулах эрх үүсгээд байна. Шинэчлэн батлагдсан аргачлалын дагуу аймгийн хэмжээнд 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс 06 дугаар сарын 09-ний өдрийг хүртэлх хугацаанд 108 өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааг хийлээ.

www.Ehalamj.mn системээр дамжуулан иргэдийн үйлчилгээг бүртгэн 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжид 7176 иргэний, жирэмсэн эхийн тэтгэмжид 142 иргэний тэтгэмжийг илгээсэн. Хүүхдийн мөнгөн тэтгэмж 7 сард 7176 хүүхдийн олголтыг үүсгэж илгээсэн.

2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт, тусламжийг 61 иргэнд үйлчилгээ үзүүлж, утсаар 50 ахмадад зөвлөгөө мэдээлэл өгч, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлтийг 1 иргэнд үзүүлсэн байна.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Хоршоо, ЖДҮ, Ахуйн үйлчилгээний чиглэлээр: Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 2023 оны 07 дугаар сарын 19-ний байдлаар нийт 1.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй, 71 зээлдэгч байна. Үүнээс хугацаа хэвийн-11, хугацаа хэтэрсэн-2, хэвийн бус-1, эргэлзээтэй-1, муу-56 байна.

Зээлийн ангиллыг сумдаар харуулбал:

Сүмбэр суманд зээлийн үлдэгдэлтэй 42 зээлдэгчийн 821,518,729 төгрөг, /хэвийн-7, хугацаа хэтэрсэн-0, хэвийн бус-0, эргэлзээтэй-0, муу-35 байна/.

Шивээговь суманд зээлийн үлдэгдэлтэй 21 зээлдэгчийн 120,609,621 төгрөг, /хэвийн-3, хугацаа хэтэрсэн-1, хэвийн бус-1, эргэлзээтэй-1, муу-15 байна/.

Баянтал суманд зээлийн үлдэгдэлтэй 8 зээлдэгчийн 173,843,138 төгрөг, /хэвийн-1, хугацаа хэтэрсэн-1, хэвийн бус-0, эргэлзээтэй-0, муу-6 байна.

“Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан”

Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу аймгийн Засаг даргын А/171 дугаар захирамжаар томилогдсон дэд хорооны 2023 оны 6 дугаар сарын 12-ны хурлаар сүүлийн шатны сонгон шалгаруулалтаа хийсэн. Дэд хорооны тогтоолоор сонгон шалгаруулалтын дүн, эрэмбэлсэн жагсаалтыг хүргүүлж, аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 15 ны А/118 захирамжаар баталгаажуулан, 3 төслийн 448'000'000 төгрөгийн төслийн дүнг сангийн мэдээллийн санд оруулж, ЖДҮГ-т хувийг хүргүүлсэн.

2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар барьцааны үнэлгээ хийгдэх шатандаа байгаа ба одоогоор гэрээ байгуулагдаж, зээл олгогдоогүй байна.

Дэд хорооны шатны шалгаруулалтад хамрагдсан ААНБ -ын мэдээлэл

№	Харилцагчийн нэр	Үйл ажиллагааны төрөл	Зээлийн дүн
1	Очирмөнх Хайрхан ХХК	Мах махан бүтээгдэхүүн болосруулах	98'000'000.00
4	Педим инсайт повер	Төмс, хүнсний ногоо зоорь	100'000'000.00
5	Өрнөх Чойр хоршоо	Эрчимжсэн мал аж ахуй	250'000'000.00
	Нийт		448'000'000.00

Хүнсний нөөцийн талаар: Хүнсний нөөцийн бодит мэдээллийг 3 сумаас авч нэгтгэв. Үүнд:

Аймгийн дүнгээр мах 4 тн буюу 4, гурил 33 тн буюу 30, сүү 3.5 тн буюу 1, төрөл бүрийн будаа 17 тн буюу 25, төмс 18 тн буюу 11.5, хүнсний ногоо 19.3 тн буюу 7, элсэн чихэр 6 тн буюу 15, давс 5 тн буюу 18, савласан ус 17 тн буюу 1, өндөг 1.6 тн буюу 11, ургамлын тос 4.2 тн буюу 18 хоногийн нөөцтэй байна.

Дээрх нөөцийг сумдаар харуулбал: /2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн байдлаар/

№	Хүнсний нэр төрөл	Сүмбэр сум			Баянтал сум		Шивээговь сум	
		Хэм жих нэгж	Тоо хэмжээ	Хоногийн нөөц	Тоо хэмжээ	Хоногийн нөөц	Тоо хэмжээ	Хоногийн нөөц
1	Малын мах	тн	2	1	1	1	1	1
2	Гурил	тн	30	55	1	6	2	6
3	Гурилан бүтээгдэхүүн	тн	2.1	1	1.4	1.6	1.6	3
4	Төрөл бүрийн будаа	тн	12.4	18	1.6	30.7	3	31
5	Сүү	тн	3.5	2				
6	Өндөг	тн	1.4	6	0.1	23	0.1	2
7	Ургамлын тос	тн	1.2	26	1	9.5	2	24
8	Төмс	тн	10	8	1	1.3	7	11
9	Хүнсний ногоо	тн	13	6	1.3	1.3	5	3
10	Элсэн чихэр	тн	3	18	1	16.6	2	19
11	Давс	тн	3	26	1	21.9	1	9
12	Савласан цэвэр ус	тн	1	1	8	0.7	8	2

2023 оны 07 дугаар сарын 19-ний байдлаар тариалалтын эцсийн мэдээгээр нийт тариалсан талбай 57.78 га, үүнээс 21.02 га-д төмс, 32.51 га-д хүнсний ногоо, 11.90 га-д тэжээлийн таримал, 3.05 га жимс, жимсгэнэ тариалсан байна.

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Ой, цөлжилт, ногоон байгууламж, биологийн олон янз байдал:

Сум дундын Ойн анги ойн зурвас, төвийн ногоон байгууламжийн талбайд усалгааг тогтмол хийж гүйцэтгэж байна.

Сүмбэр сумын 3-р баг, Баянбулгийн 8-1004 тоот хаягтай иргэн Н.Бат-Эрдэнийн хашаанд **Эрээн хүрэн** гэдэг амьтан орж ирсэн гэх мэдээллийн дагуу аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын холбогдох албан хаагчид тус амьтныг байгальд аюулгүйгээр тавьсан.

Энэхүү Эрээн хүрэн гэдэг амьтан нь улаан номонд бүртгэлтэй, ховор зүйл. Говь цөлийн бүсэд нэн ховор, суусарын овгийн жижиг махчин амьтан юм. Нас бие гүйцсэн, бие 35 см, жин 0,50 кг, толгой жижиг, хоншоор богиновтор мохоодуу, чих том угаараа өргөн, дэлбэгэр дугуй, сүүл урт сагсгар, зоо нуруу биеийн хажуу халиун бор дэвсгэр дээр элдэв хэлбэрийн цайвар толбуудтай.

БНХАУ-ын 3 судлаач манай аймагт айлчилж, цөлжилтийн судалгааны төвийн үйл ажиллагааг бэхжүүлж, хамтран ажиллах боломжийн талаар ярилцаж, газар дээр нь танилцсан.

Хүрээлэн буй орчны бохирдол, газрын асуудлын хүрээнд:

Салбарын улсын ерөнхий байцаагчийн 2023 оны 01/08 дугаартай “Техникийн ашигласан тос, хаягдал аккумуляторыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу Шивээ-Овоо ХК-нд хяналт шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага өгч ажилласан.

Үндэсний баяр наадмаар хог хаягдалгүй наадах уриалга гаргаж Баянтал, Шивээговь, Сүмбэр суманд бүх нийтийн цэвэрлэгээ зохион байгуулж, 33 байгууллага 2,4 тн хог хаягдал цэвэрлэсэн.

“Жорлонгоо өөрчилъе” аяны хүрээнд иргэдэд байгальд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах, ХААН, ХАС, ТӨРИЙН банкуудаар ногоон зээлд хамрагдах боломжтой болсон талаарх мэдээллийн цахимаар болон 8 иргэнд гарын авлага, мэдээлэл өгсөн.

Байгаль орчны үнэлгээ, усны асуудлын хүрээнд:

Умард говийн Гүвээт Халхын Дундад талын Сав Газартай хамтран аймгийн хэмжээнд усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс, ус хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн мужийн заагийг ИТХ-аар шинэчлэн тогтоох, усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсэд тэмдэгжүүлэлт хийх ажлыг хийж гүйцэтгэж байна.

Ус ундрах ХХК-ний гүйцэтгэж байгаа ногоон багууламжийн усалгааны зориулалттай гүй өрмийн худаг гаргах ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.

Шивээговь сумын иргэдээс ирсэн мэдээллийн дагуу Байгаль орчны салбарын хяналтын хүрээнд Шивээговь сумын нутаг дэвсгэр, Шивээ-Овоо уурхайн урд байрлалтай Цотан жанжин транс ХХК-ны үйлдвэрлэлийн зориулалтаар эзэмшихээр авсан газарт хяналт шалгалт явуулсан. Тус газарт Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэлгүй, байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулахгүйгээр үйл ажиллагаа явуулж, их хэмжээний нүүрс буулгахаар хүнд даацын олон машин маршрутын бус замаар тээвэр хийж цуваа үүсгэн, 510 тн нүүрс буулгасан зөрчлийг таслан зогсоож, Зөрчлийн хуулийн 7.1.1-д заасны дагуу Байгаль орчны хяналтын ахлах байцаагч 3,0 сая төгрөгийн торгууль ногдуулсан.

Шивээговь сум Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд зам дагуух ногоон байгууламжийн мод, ойн зурвасын 4 га газрын мод бутыг хөдөлмөр халамжийн “Мод бут тарих ажлын хүрээнд 2023 оны 07дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн мод бутыг услах арчилах ажлыг 6 иргэнтэй гэрээ байгуулан тогтмол хийлгэж байна. Мөн Шинэлэг Шивээговь төслийн хүрээнд 6 иргэнтэй гэрээ байгуулан, нийтийн эзэмшлийн зам талбайн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулж байна. Нийтийг хамарсан ажилд ажилласан 12 иргэнд өдөр бүр халдвар хамгааллын дэглэмийг баримтлан ажиллах хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зааварчилгааг өгч, гарын үсэг зуруулан хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, амны хаалт өгсөн.

Баяр наадмын өдрүүдээр амралт зугаалгаар явж байгаа иргэдэд үер усны аюулаас сэргийлэх, сэрэмжлүүлэг хүргэж, хэрлэн гол хаялага нуур, Чойрын богд уулын чиглэлд эргүүл хяналт шалгалт хийж, хог хаягдлын зөрчлийг арилгуулж, хууль бус агнуур хийж буй зөрчлийг таслан зогсоож, 1 тор хураасан.

Аялал жуулчлалын ажлын хүрээнд:

Аялал жуулчлалыг хөгжүүлэх тур операторуудтай хамтран ажиллах, түншлэлийн уулзалтын үр дүнд хамтран ажиллах гэрээ байгуулснаар Боржигин голомт жуулчны бааз ОХУ, Буриад, Хятад улсын жуулчдыг хүлээн авсан. 7 сард нийт дотоодын 1200 гаруй аялагч, гадаадын 40 гаруй жуулчин хүлээн авсан.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар:

Умард говийн гүвээт ,халхын дундад сав газрын захиргаа, аймгийн Байгаль орчин ,аялал жуулчлалын газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар хамтран 2023 оны 07 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд Сүмбэр сумын хэмжээнд 24 булаг, гол, нуурын тооллогын ажлаар газар дээр очиж солбицолжуулах, зурагжуулах хээрийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн.

Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн А/191 дугаар захирамжаар газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг Сүмбэр сумын 2 дугаар багт, аймгийн холбооны газрын баруун талд 0.0906 га /906м²/ газрыг худалдаа, нийтийн

үйлчилгээний газар, төв, цогцолборын зориулалтаар 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажлаад байна.

Хот тосгон, бусад суурин газрын мониторингийн цэгт хөрсний бохирдлын судалгааны ажлын хүрээнд аймгийн төвийн суманд 10 цэгт хөрсний дээж авахаар ажиллаж байна.

Барилга, хот байгуулалтын хэлтэс:

2023 оны 06 дугаарсарын 30-ны өдөр Барилга, хот байгуулалтын яам, Барилгын хөгжлийн төв хамтран зохион байгуулсан Барилга угсралтын ажлын чанар улсын форумд байгууллагын 2 албан хаагч оролцлоо.

Сүмбэр сумын 3 дугаар багийн иргэн Л.Элбэгийн 2 давхар худалдаа үйлчилгээний зориулалттай барилгад 2023 оны 07дугаар сарын 05-ны өдөр улсын комисс ажиллаж, үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад оруулахаар шийдвэрлэлээ.

Аймгийн төвийн 2.8 км автозамын ажилтай захиалагч, гүйцэтгэгч, зохиогч байгууллагын төлөөллүүд 2023 оны 07 дугаар сарын 20-ний өдөр газар дээр нь үзлэг шалгалт хийж ажиллалаа. Ажлын гүйцэтгэл 75 хувьтай явагдаж байна.

Сүмбэр сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт баригдаж байгаа Боржигон чуулгын барилгын гадна дотно ханын өрлөгийн ажил хийгдэж байна. Ажлын явц 93 хувьтай байна.

Худалдан авах ажиллагааны талаар:

Төлөвлөгөөний биелэлтийг санхүүжилтийн эх үүсвэрээр нь ангилбал:

- **Улсын төсвийн хөрөнгө оруултаар 4,194,800.0** мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөнөөс:
 - ✓ Үнэлгээ хийгдэж байгаа төсөл арга хэмжээ – 1 / 85,000.0 мянган төгрөг/
 - ✓ Гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ -1 / 4,109,800.0 мянган төгрөг/

Төлөвлөгөөний биелэлт 50 хувь.

- **Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар**
- **921,869,4** мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 5 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөнөөс:
 - ✓ Тендерийн шалгаруулалтыг цахим хэлбэрээр зарласан төсөл арга 2/ 414,876.0 мянган төгрөг/
 - ✓ Гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ – 3 / 506,992.6 мянган төгрөг/

Төлөвлөгөөний биелэлт 70 хувь.

- **Аймгийн “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр 671,868.60** мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 15 төсөл арга хэмжээ төлөвлөснөөс:
 - ✓ Тендерийн шалгаруулалтыг цахим хэлбэрээр зарласан төсөл арга хэмжээ – 1 / 70,000.0 мянган төгрөг/
 - ✓ Гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ - 9 / 893,140.0 мянган төгрөг/

Төлөвлөгөөний биелэлт 60 хувь.

- **Аймгийн “Авто замын сан”-ийн хөрөнгөөр 440,616.5** мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 ажил төлөвлөснөөс:
 - ✓ Гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ – 1 / 440,616.5 мянган төгрөг

Төлөвлөгөөний биелэлт

100 хувь.

- **Аймгийн “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал”**-аар 28,702.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 ажил төлөвлөснөөс:
 - ✓ Гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ – 1 / 28,702.0 мянган төгрөг
 Төлөвлөгөөний биелэлт 100 хувь.
- **Аймгийн “Бусад хөрөнгө оруулалт”**-аар 28,702.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 ажил төлөвлөснөөс:
 - ✓ Гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ – 1 / 100,000.0 мянган төгрөг
 Төлөвлөгөөний биелэлт 60 хувь

Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-т заасныг үндэслэн худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгон зарласан байна. Үүнд:

- Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарласан - 12
- Харьцуулалтын аргаар - 8
- Зөвлөх үйлчилгээний тендер – 5

Орон нутгийн өмчийн талаар: Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн ашиглах суудлын автомашины тоо, төрөл зориулалтыг батлах тухай Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/179 дугаар захирамж гарсантай холбоотой холбогдох 25 байгууллага буюу аймгийн Иргэдийн Төлөөлөгчийн Хурал, аймгийн Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, Цагдаагийн хэлтэс, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Боловсрол шинжлэх ухааны газар, Аймгийн нийтийн номын сан, Ус-Ду ОНӨААТҮГ, Биеийн тамир спортын газар, Орон нутгийн өмчит газар, Боржигин чуулга, Сүмбэр сумын ЗДТГ, Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Энхтүсдэм, Шивээговь сумын ЗДТГ, Илчлэг шивээ, Эрүүл мэндийн төв, Баянтал сумын ЗДТГ, Эрүүл мэндийн төв, 4-р сургууль, Талын илч ОНӨААТҮГ газарт тус тус захирамжийг хүргүүлж ажилласан. Татан төвлөрүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Одоогоор татан төвлөрүүлэх 4 автомашиныг холбогдох газарт байршуулсан байна. Орон нутгийн өмчит байгууллага болох Сум дундын ойн ангийн өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалт, түүний зарцуулалтын байдалд бүртгэлээр хяналт хийх ажлын удирдамж боловсруулан 2023 оны 07 дугаар сарын 19-28-ны өдрүүдэд хяналтыг хийхээр төлөвлөн ажиллаж байна.

2023 оны түрээсийн орлогод 07 дугаар сарын 24-ны өдрийн байдлаар 23,9 сая төгрөг төвлөрөөд байна.

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР